



Захиргааны хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2020 оны 01.. сарын 24.-ны  
өдрийн 466 дугаарт бүртгэв.

## ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 4265

Улаанбаатар хот.

### Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1.“Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох, баталгаажуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлагын хэлтэс /Б.Батсайхан/, Татварын хяналт шалгалт, арга зүйн газар /О.Тэнгис/, Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 531 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Татварын ерөнхий газрын гарын  
19... оны ... сарын ...-адрийн  
алдагдлыг дагаар түүлахад хавсралт

**АЖ АХҮЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАНГААР ГАРСАН  
АЛДАГДЛЫГ ИРЭЭДҮЙД ШИЛЖҮҮЛЭН ТООЦОХ, БАТАЛГААЖУУЛЖЖИРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан татварын тайлангаар гарсан алдагдал /цаашид “алдагдал” гэх-/ыг баталгаажуулах, ирээдүйд шилжүүлэн тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Татвар төлөгчийн хуулийн дагуу тайлагнасан татварын тайланг эрсдэлийн үнэлгээний системийн үр дүнг үндэслэн татварын алба баталгаажуулж, алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцоход энэ журмыг мөрдөнө.

1.3. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.2-т заасны дагуу татварын албаар баталгаажуулсан татварын тайлангаар гарсан алдагдлыг дараалсан 4 жилд шилжүүлэн тооцно.

1.4. Шилжүүлэн тооцох алдагдал нь тухайн жил бүрийн татвар ногдуулах орлогын 50 хувиас хэтрэхгүй бөгөөд дараалсан 4 жилд шилжээгүй үлдсэн алдагдлыг цаашид татвар ногдуулах орлогоос хасаж тооцогч.

1.5. Татварын тайлангаар гарсан алдагдлыг Татварын ерөнхий хуулийн 28.8-д заасны дагуу Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр баталгаажуулж, шилжүүлэн тооцно.

1.6. Ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлын нийт дүн нь татварын албаны баталгаажуулсан алдагдлын нийт дүнгээс хэтрэхгүй байна.

**Хоёр. Татварын тайлангаар гарсан алдагдлыг баталгаажуулах**

2.1. Тухайн тайлант жилд алдагдалтай ажилласан татвар төлөгч нь “Татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэх тооцоо” ТТ-02 маягтыг нөхөж, цахим тайлангийн системд “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан” ТТ-02 маягтын хамт хуулийн хугацаанд татварын албанд илгээнэ.

2.2. Эрсдэлийн үнэлгээний системээр хүлээн зөвшөөрөх, бага, дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн татвар төлөгчийн алдагдлын дүнг татвар төлөгчтэй харилцах асуудал хариуцсан нэгж баталгаажуулна. Баталгаажуулсан алдагдлын дүн нь татварын хяналт шалгалтаар өөрчлөгдөхгүй байх үндэслэл болохгүй.

2.3. Энэ журмын 2.2-т зааснаас бусад эрсдэлтэй гэж үнэлэгдсэн татвар төлөгчийн алдагдлын дүнг хяналт шалгалт хариуцсан нэгж баталгаажуулна.

2.4. Хяналт шалгалт хийсэн татварын улсын байцааг нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлсэн тооцоо “маягт ХШ-11”-г жил бүрээр үйлдэж нөхөн ногдуулалтын акт, илтгэх хуудсанд хавсаргана.

2.5. Татварын хяналт шалгалтын үр дүнд алдагдлын хэмжээ өөрчлөгдсэн тохиолдолд энэ журмын 2.4-т заасан маягтаар баталгаажсан алдагдлын дүнг Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

2.6. Хяналт шалгалтаар тухайн тайлант жилийн алдагдлыг нэмэгдүүлсэн тохиолдолд дараагийн онуудад шилжүүлэн тооцох алдагдлыг Маягт ХШ-11 маягтаар баталгаажуулж Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

2.7. Хяналт шалгалтад хамрагдсан хамгийн сүүлийн оны ХШ-11 маягтын шилжээгүй үлдсэн алдагдлыг дараагийн жилүүдэд шилжүүлэн тооцно.

**Бүртгэлийн дугаар .../20.....**

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

**ХУУЛБАР ҮНЭН**

Хуулбар олгосын ажилтны гарын үсэг

20... оны ... сарын ...-ний өдөр

2.8.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.5-д заасны дагуу тусгай зөвшөөрөл тус бүрээр нь алдагдлыг баталгаажуулна.

2.9.Татварын өрөнхий хуулийн 39, 40 дүгээр зүйлд заасан үнэ шилжилтийн тохируултыг Татварын тайлангаар гарсан алдагдлыг баталгаажуулахдаа ашиглана.

#### **Гурав.Алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох үйл ажиллагаа**

3.1.Баталгаажуулсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцоходоо эхэлж гарсан алдагдлыг эхэнд шилжүүлэх зарчим баримтална.

3.2.Өмнөх жилүүдийн алдагдал шилжиж дуусаагүй тохиолдолд дахин алдагдал үүссэн бол уг шилжээгүй үлдсэн алдагдлыг энэ журмын 1.3-т заасан хугацаанд шилжүүлэн тооцно.

3.3.Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл тус бүрээр баталгаажуулсан алдагдлыг шилжүүлэн тооцоходоо энэ журмын 1.3, 1.4-т заасныг баримтална.

3.4.Алдагдлыг дараах тохиолдолд шилжүүлэн тооцохгүй:

3.4.1.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаа дууссан, цуцлагдсан, буцаан өгсөн тохиолдолд алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохгүй.

3.4.2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19.8-д заасан аж ахуйн нэгж өөрчлөн байгуулагдсан тохиолдолд хасагдаагүй үлдсэн алдагдлыг шилжүүлэн тооцохгүй.

3.4.3.татварын хялбаршуулсан горим ашиглах татвар төлөгчийн өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцохгүй.

